



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/626

Ховд

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2, 9.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчилах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

-Аймгийн Засаг дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга
-Жаргалант сумын Засаг дарга
-Мэргэжлийн хяналтын газрын Авто замын
хяналтын улсын байцаагч
-Ховд АЗЗА төрийн өмчит улсын
үйлдвэрийн газрын дарга
-Аймгийн автотээврийн төвийн дарга

Нарийн бичгийн
дарга:

-Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Замын
цагдаагийн тасгийн дарга

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн тогтоол, түүний хавсралтуудад заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэн, тайланг хагас, бүтэн жилээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлж байхыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/626 Ch
02 03122